



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 04 сарын 24 өдөр

Дугаар А/33

Улаанбаатар хот

Нийслэлийн Нийтийн тээврийн газрын
данс бүртгэлээс тээврийн хэрэгсэл хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор баталсан "Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам"-ын 4 дүгээр зүйл, Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/336 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Техникийн комиссын дүгнэлтээр ашиглалтын шаардлага хангахгүй болсон, засаж сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тогтоогдож, сэлбэгийн буюу хоёрдогч түүхий эдийн зориулалтаар татан төвлөрүүлж худалдахаар шийдвэрлэгдсэн нийт 124,645,999.00 (нэг зуун хорин дөрвөн сая зургаан зуун дөчин таван мянга есөн зуун ерэн ес) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий үлдэгдэл өртөггүй 2 тээврийн хэрэгслийг хавсралтын дагуу данс бүртгэлээсээ хасахыг нийслэлийн Нийтийн тээврийн газар (С.Жавхланбаатар)-т зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй тээврийн хэрэгслийг нийслэлийн Өмчийн харилцааны газарт актаар хүлээлгэн өгч, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийх, тээврийн хэрэгслийн гэрчилгээ улсын дугаарыг хураан авч авто тээврийн улсын бүртгэл, татварын бүртгэлээс хасуулахыг нийслэлийн Нийтийн тээврийн газар (С.Жавхланбаатар)-т үүрэг болгосугай.

3. Татан төвлөрүүлж буй хөрөнгийг худалдан борлуулах ажлыг зохион байгуулж, үр дүнг тайлагнахыг Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтэс (М.Мөнхбаяр)-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтэс (Ц.Цэрэндулам)-т тус тус даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ч.САЙХАНБАЯР

D:\НӨХГ\Тушаал 2023\А тушаал.docx

1150500019

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын
2023 оны 04 дугаар сарын 24 -ны өдрийн
А/33 дугаар тушаалын хавсралт

Сэлбэгийн буюу хоёрдогч түүхий эдийн зориулалтаар татан төвлөрүүлж худалдах тээврийн хэрэгслийн жагсаалт

д/д	Автомашины марк, улсын дугаар	Үйлдвэр- лэсэн/ Монголд ашиглаж эхэлсэн он	Зориулалт, аль улсад үйлдвэр - лэсэн, өнгө	Арлын дугаар	Нийт гүйлт (км)	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг	Эвдрэл гэмтэл	Сэлбэг болон хоёрдогч түүхий эдийн зориулалтаар худалдах доод үнэ (төгрөг)
1	Хьюндай HD- 72 11-52 УНУ	2013/2013	Крантай чирэгч	KMFGA17LPDC225630	60337	114,079,999.00	114,079,999.00	Явах эд ангийн ашигт нормоос хэтэрсэн элэгдэл, караказ зэвэрч муудсан, зорчигчийн заал болон шалны битүүмж алдагдсан, хөдөлгүүрийн түлш, маслоны зарцуулалт ихэссэн		800,000
2	Истана 18-71 УБЗ	2007/2007	Суудал БНСУ хар ногоон	KPDAB5E8IXPO75477	244429	10,566,000.00	10,566,000.00	зэрэг нь Монгол улсын замын хөдөлгөөний дүрмийн 2-р хавсралтын 3.1, 3.2-р заалтуудыг зөрчиж байгаа бөгөөд цаашид ашиглалтын шаардлага хангахгүй болсон гэж акт тогтоосон байна.		800,000
Нийт дүн						124,645,999.00	124,645,999.0	-	-	1,600,000.0